

## ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧНИЙ ХАНГАМЖИЙН 20 .. ОНЫ СУДАЛГАА

### 1.Хаягийн хэсэг

	код	
Дүүргийн нэр:		
Хорооны дугаар:		

- 1.Хорооны Засаг дарга нь жил бүрийн 12-р сарын 20-ны дотор бүртгэлийг цахим дүүргийн ЗДТГ-т хүргүүлнэ.
- 2.Дүүргийн ЗДТГ нь бүртгэлийг хянаж, нэгтгэн нь 12-р сарын 25-ны дотор УБ хотын ЗАА цахим хэлбэрээр хүргүүлнэ.
- 3.УБ хотын ЗАА нь ҮСХ-нд жил бүрийн 12-р сарын 30-ны дотор цахим хэлбэрээр хүргүүлнэ.

### 2.Мэдээний хэсэг

Цахилгааны эх үүсвэр	МД	Өрхийн тоо	ААНБ-ын тоо
А	Б	1	2
Бүгд мөр 1= мөр(2+12)	1		
Цахилгааны эх үүсвэртэй мөр 2=мөр(4+6+8+10)	2		
Цахилгааны хүчдэлийн түвшин хангалтгүй мөр 3=мөр(5+7+9+11)	3		
Төвлөрсөн систем	<b>4</b>		
Цахилгааны хүчдэлийн түвшин хангалтгүй	5		
Дизель станц	<b>6</b>		
Цахилгааны хүчдэлийн түвшин хангалтгүй	7		
Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж	<b>8</b>		
Цахилгааны хүчдэлийн түвшин хангалтгүй	9		
Бага оврын цахилгаан үүсгүүр	<b>10</b>		
Цахилгааны хүчдэлийн түвшин хангалтгүй	11		
Цахилгааны эх үүсвэргүй	12		

Бүртгэсэн: Албан тушаал: \_\_\_\_\_

Гарын үсэг: \_\_\_\_\_ \

Тамга\тэмдэг

Хянасан: Албан тушаал: \_\_\_\_\_

Гарын үсэг: \_\_\_\_\_ \

## ЭАБ-6 МАЯГТЫГ НӨХӨХ ЗААВАР

Хорооны засаг дарга нь цахилгаан эрчим хүчний хангамжийн судалгааг маягтын дагуу нэгтгэн гаргана. Судалгааг "Хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтэр"-т үндэслэсэн "Хүн ам, өрхийн мэдээллийн сан"-г ашиглан гаргана.

### 1. ХАЯГИЙН ХЭСЭГ

**Байршил:** Дүүргийн нэрийг бүтнээр бичиж, Багануур дүүрэг- **01**, Багахангай дүүрэг- **04**, Баянгол дүүрэг- **07**, Баянзүрх дүүрэг- **10**, Налайх дүүрэг- **13**, Сонгинохайрхан дүүрэг- **16**, Сүхбаатар дүүрэг- **19**, Хан-Уул дүүрэг- **22**, Чингэлтэй дүүрэг- **25** гэсэн кодыг зохих нүдэнд нөхнө. Хорооны дугаарыг "Хүн ам"-ын мэдээллийн санг байгуулах заавраас харж нөхнө.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн кодыг Нийслэлийн Статистикийн газар (328787, 327946), дүүргийн Статистикийн хэлтсээс болон [www.ubstat.mn](http://www.ubstat.mn) цахим хуудсаас харах боломжтой.

### 2. МЭДЭЭНИЙ ХЭСЭГ

**1 дүгээр мөрийн 1 дугаар баганад:** Харьяа дүүргийн статистикийн хэлтсээс зөвшөөрсөн өрхийн тоог нөхнө.

**1 дүгээр мөрийн 2 дугаар баганад:** Тайлант жил тухайн хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгж, байгууллагын тоог нөхнө.

**2 дугаар мөрөнд:** Цахилгааны эх үүсвэртэй нийт өрх, аж ахуй нэгж байгууллагын /ААНБ/ тоог нөхнө.

**3 дугаар мөрөнд:** Цахилгааны хүчдэлийн түвшин хангалтгүй өрх, ААНБ-ын тоог нөхнө. Цахилгааны хүчдэлийн түвшин хангалтгүй гэдэгт цахилгаан дамжуулах болон түгээх сүлжээний ажиллагаа хэвийн байх нөхцөлд хэрэглэгчийг тэжээж байгаа цэг дэх хүчдэл хэвийн утгаасаа доош хэмжээнд байхыг хэлнэ. Жишээ нь: өрх, аж ахуйн нэгж нь цахилгааны ид ачааллын үед өөрсдийн цахилгаан хэрэгслээ бүрэн ашиглах боломжгүй байх, тухайлбал, чийдэнгийн асалт бүдгэрэх, нэг зэрэг 2-3 цахилгаан хэрэгслийг ашиглах боломжгүй байх гэх мэт.

**5, 7, 9, 11 дүгээр мөрөнд** тухайн цахилгааны эх үүсвэрийн төрөл тус бүрээс цахилгааны хүчдэлийн төвшин хангалтгүй өрх, ААН-ийн тоог нөхөж бичнэ.

**4 дүгээр мөрөнд:** Төвлөрсөн системд холбогдсон цахилгааны эх үүсвэртэй өрх, ААНБ-ын тоог нөхнө. Төвлөрсөн системтэй өрх, ААНБ-д улсын цахилгаан болон усан станцаас цахилгаанаа авдаг өрх, ААНБ-ын тоог оруулж тооцно. Гэхдээ айл өрх, албан байгууллагууд төвлөрсөн системд холбогдохын зэрэгцээ өөр бусад (сэргээгдэх, бага оврын болон дизель гэх мэт) цахилгааны нөөц эх үүсвэртэй бол цахилгаан эх үүсвэртэй хэсэгт давхардуулан тооцож болохгүй.

**6 дугаар мөрөнд:** Дизель станцад холбогдсон цахилгааны эх үүсвэртэй өрх, ААНБ-ын тоог нөхнө. Дизель станц гэж тусгайлан барьсан дизель станцад холбогдсон цахилгааны сүлжээг ойлгоно.

**8 дугаар мөрөнд:** Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмжөөр цахилгааны эх үүсвэрээ авч байгаа өрх, ААНБ-ын тоог нөхнө. Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмжинд нар, салхины эрчим хүчийг хуримтлуулан цахилгаан эрчим хүч болгодог төхөөрөмжийг хамруулна.

**10 дугаар мөрөнд:** Бага оврын цахилгаан үүсгүүртэй өрх, ААНБ-ын тоог бичнэ. Бага оврын цахилгаан үүсгүүрт тухайн нэг өрх болон хэсэг өрхийн хэрэгцээг хангах зорилгоор шатах болон бусад материалаар ажилладаг бага оврын мотор, цахилгаан үүсгүүрийг хамруулна.

**12 дугаар мөрөнд:** Цахилгааны эх үүсвэргүй өрх, ААНБ-ын тоог нөхнө. Цахилгааны эх үүсвэргүй өрх, аж ахуйн нэгж, байгуулагад төвийн эрчим хүчний системд холбогдоогүй, ямар нэгэн бусад эх үүсвэр ашигладаггүй, сэргээгдэх эрчим хүч бага хэмжээгээр ашиглаж байгаа боловч хэрэгцээгээ бүрэн хангаж чаддаггүй өрхийг хамруулна.